

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
10 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.10 Хугацаа 80 минут А хувилбар Хэрлэн сум
Нийт оноо: 40 Анги: Сурагчийн нэр:

Эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

Учиртай гурван толгойн Хоролмаа

Зэрвэсхэн салхиар хөглөсөн зэлүүдхэн орчлонг зэрэглээ шиг цэнхэр аялгуу эзгүйчилнэ. Зэрэглээ шиг цэнхэр аялгуу дагуулсан ардын дуунд шингэж ардын дуу шиг түмнийхээ дунд Учиртай гурван толгойн Хоролмаагийн дүрээр мэнхэрсэн Монгол улсын Гавьяат жүжигчин Ванчигданзангийн Сүрэнхорлоо дуучин нь Булган аймгийн Хишиг-Өндөр сумын уугуул. Хар багаасаа л ардын дуунд өлгийдүүлж өсөж өндийсэн гэдэг юм билээ. Хаана найр болно, тэнд хэдийнээ гүйгээд хүрчихсэн гэрийн үүдэнд цомцойн эсвэл гэрийн хаяанд чимээгүйхэн сууж хүмүүсийн дуулахыг чих тавин хичээнгүй чагнан сэтгэлээ баясгадаг байжээ. Ийнхүү ардын дуугаар хөглөгдөж явсаар Сүрэнхорлоо Нийслэл хүрээг зорьж Үйлдвэр комбинатын соёлын ордоос уран бүтээлийн гараагаа эхлэн Бөмбөгөр ногоон театрт ирснээр "Учиртай гурван толгой" дуулалт жүжгийн Хоролмаад тоглох хүндхэн бөгөөд хүндтэй аз завшаан тохиосон гэдэг. "Зохиогч нь тодорхойгүй ч ахуй соёлоо гээгүй түмний минь үе уламжилж ирсэн ардын дууны нугалаа бадаг бүрээс аргалын утаа уугих шиг болдог оо" хэмээн Сүрэнхорлоо нэгэнтээ хэлсэн байдаг. Тийнхүү ардын дууны гайхамшигийг яс мах, эд эсээрээ мэдэрсэн болохоор Хоролмаагийн дүрээ бүтээхэд түүнд дөхөм байсан болов уу гэж санагддаг юм.

Улсын Хөгжимт драматик театр одоогийн Дуурь, бүжгийн эрдмийн театрыг үндэслэн байгуулалцсан Оросын мэргэжилтэн Смирновын удирдлаган дор мэргэжил дээшлүүлэх курс төгссөн Сүрэнхорлоо Ардын жүжигчин, төрийн шагналт Жамъянгийн "Миний баясгалан" хөгжимт жүжгийн Норжмаа, Дулмаа, Ардын жүжигчин, төрийн хошой шагналт Б.Дамдинсүрэнгийн "Ийм нэгэн хаан" хөгжимт жүжгийн зээж, "Учиртай гурван толгой" дуурийн Хоролмаагийн дуруудийг чадварлаг бүтээн, Гавалмаа, Бээжин хот, Ганьхуар цаас, Найгал гол, Гантэмэр, Аглаг өндөр уул, Бидний хувцас, Лоолой зэрэг ардын дууг түмнийхээ сэтгэлд хоногшуулж Улс хувьсгалынхаа 35 жилийн ойгоор 1956 онд 194 тоот зарлигаар Монгол улсын "Гавьяат жүжигчин" хэмээх эрхэм алдрыг хүртжээ.

Цаг хугацааны тохиолд ардын дууны од болон гийж цаанаа л авьяас билгийн охин тэнгэр байсан Сүрэнхорлоогийн тухай дурсан ярих хүн гарын арван хуруунд багтахгүй олон. ... Дуучин болох замыг засах, аяны харгүй нь урмаар мляасан үе үеийн гарын шавь нарынх нь нэг Монгол улсын Гавьяат жүжигчин Үенч "Багш минь үнэхээр гайхамшигтай сайхан ардын дуучин байсан. Ардын дуундаа хайртай. Өөрийгөө залгамжилсан ардын дуучдыг гаргая гэж эрмэлзэг байсан. Багшийг хүмүүс Хоролмаагийн дүрээр төсөөлөөд байдаг. Багш Хоролмааг "18 дугаар зууны сүүл 19 дүгээр зууны эхэн үед амьдарч байсан бүсгүй, хайр сэтгэлийнхээ төлөө тэмцэж яваа сайхан эмэгтэй" гэж босгосон дүрээ маш их магтдаг байв. Багш хурц ширүүн харагддаг. Гэхдээ маш зеелен, хүний төлөө тусалдаг. Багшийн амнаас хүнийг тэр тийм гэж муулж байхыг сонсоогүй. Дуурийн театртаа хайртай. Томчууд "Ардын дуу бүржигийн чуулгад оч" гэж зөвлөдөг байсан юм билээ. Дуурийн театрыг байгуулсан цагаас нь ажилласан учраас би театраа орхиж чадаагүй гэж ярьдаг байсан. Манай алтан үеийнхэн "Бид тийм юм үлдээнэ" гэсэн бодолтой хүмүүс байжээ. Надад монгол ардын дуу Лоолой, Хандармаа, Цонхон дээр сусан ялаа, Сүнжидмаа зэрэг олон дууг ингэж дуул гэж зааж өгсөн. Би анх 1985 онд дэлхийн Залтуучууд оюутны 12 дугаар их наадамд явахаар Булганаас ирээд Сүрэнхорлоо гуайтай уулзаж, хоолойгоо шалтуулж чамд ийм дуу зохих юм байна гээд дуугаа засуулж, ардын дууны ая дангийн учрыг хэлүүлж байсан. Багш олон юмыг мэдүүлсэн. Манай "Түмэн эх" чуулгад "Учиртай гурван толгой" дуулалт жүжигийг Эрдэнэбулган найруулж тавихад Сүрэнхорлоо багш Нансалмаа, Хоролмаа, Юндэн, Балганы ардын дуун дээр нь зөвлөх багшаар ажилласан. Бид ардын дууны маневрыг мэдэж авсан. Сайхан дуулалт жүжиг болж билээ. Тэр жилдээ "Шилдэг уран бутзээл" болж, би Нансалмаад тоглож байлаа" хэмээн ярина.

Хоролмаа гэж "Учиртай гурван толгой" дуурийн эсрэг талын дүр ч гэсэн нөгөө талаар хайр сэтгэлийнхээ төлөө тушттай зогссон бүсгүйн зан араншин, дотоод зөрчил тэмцлийг үзэгч түмний хорсол зэвүүцлийг төрүүлэхүйцээр илэрхийлж чадсан анхны Хоролмаа бол яах аргагүй Сүрэнхорлоо гавьяат. Хосгүй авьяас, хоолойн цараагаараа нэгэн үе монголын Дуурийн театрьг төдийгүй үзэгч түмнийг "Учиртай гурван толгой" дуурийн Хоролмаагийн дүрээр эзэмдэж байсан Сүрэнхорлоогийн гаргасан ардын дууны түүхэн жимээр ар араасаа булган суулттай олон сайн дуучид төрсөөр байна. ... Сүүн даллагатай хүний орчлонд хэдийгээр сүүдрээ орхин одсон ч ардын дуугаараа нэрээ мэнхелж ард олныхоо дунд ам дамжин хэзээ ч мартагдахгүй дурсагдмуй. ([МУГЖ](#)
[В Сүрэнхорлоогийн хөөгээ найруулал \(youtube.com\)](#))

1. Өгүүлбэрүүдийн тэгс бус өгүүлэхүүн гишүүний илрэх байдлыг ажиглан, дүгнэлт гарган зөв харгалзуулаарай. /4 оноо/

A. Хүмүүсийн дуулахыг хичээнгүй чагнадаг байжээ.	1. Цагийн байц гишүүн өгүүлбэртэй УНӨ
Б. Зэрвэсхэн салхиар хөглөсөн зэлүүдхэн орчлонг зэрэглээ шиг цэнхэр аялгуу эзгүйчилнэ.	2. Холимог нийлмэл өгүүлбэр
В. Бөмбөгөр ногоон театрт ирснээр "Учиртай гурван толгой" дуулалт жүжгийн Хоролмаад тоглох хүндхэн бөгөөд хүндтэй аз завшаан тохиосон гэдэг.	3. Нэрийн хамжсан тодотгол гишүүн өгүүлбэртэй УНӨ
Г. "Учиртай гурван толгой" дуулалт жүжгийг Эрдэнэбулган найруулж тавихад Сүрэнхорлоо багш Нансалмаа, Хоролмаа, Юндэн, Балганы ардын дуун дээр нь зөвлөх багшаар ажилласан.	4. Шууд тусагдахуун гишүүн өгүүлбэртэй УНӨ

Түлхүүр:

2. Эхэд байгаа "Багш хурц ширүүн харагддаг. Гэхдээ маш зөвлөн, хүний төлөө тусалдаг." гэсэн өгүүлбэрийн тодруулсан үгийн үүргийг тодорхойлж, утга ойролцоо үзээр солин найруулаарай. /4 оноо/

Үүрэг:

Солин найруулсан нь:

3. Өгүүлбэрт онцолсон бүтээврийг солин найруулж бичээд, холбох үгийн утгыг тайлбарлаарай.

14 оноо 1

"Багшийн амнаас хүнийг тэр тийм гэж муулж байхыг сонсоогүй"

Солин найруулсан нь:

Утгын

тайлбар:

4. Зөв бичих дүрмийн даалгавар 14 оноо

А. Дараах үгсээс алдаатай бичсэн 1 үгийг олоод, зөв болгон бичээрэй.

Үгс: Хоморго, завдсаныг, сагалдрага, оношилгоо, сэргээнэх, завьяа

Алдаатай үг: Зөв болгосон нь:

Б. хавсар + лт үгийн язгуур үндсэнд бүтээврийг залгаж бичээд, дүрмийг тайлбарлаарай.

Үг:

Дүрэм:

5. Уран зохиолын даалгавар: /9 оноо/

А. Д.Нацагдоржийн "Хөдөө талын үзэсгэлэн" өгүүллэгийн онцолсон хэсгийн хам сэдвийг тодорхойлоорай. /2 оноо/

Өвгөн жолооч ухасхийх, хийг нэмэхэд дөрвөн хүрд чөлөө завгүй эргэлдэнэ. Бүртэлзэн харагдагч бараа нэг үе далд орж, нэг үе ил гарна. Удалгүй бүртэлзэн цухуйж, алтан ганжурууд нь өглөөний нарны гэрэлд үзэсгэлэнтэй гялалзана. Тэрхүү хийдийн суваргын тэнд **гайхамшигтай манжлага цамхагт өлгесэн хонхны дуу хангинан жингэнэнэ**. Бүрээ, бишгүүрийн дуу үргэлжлэн дүнгэнэнэ. Цам, жахар бүжиглэж байгаа юм байжээ. Хөдөөгийн хүмүүс хэд хэдэн зуугаар хуралдаад, эрээн мярааныг өмсөж, ийш тийш зөрөлденө.

Хам сэдэв:

Б. Д.Намсрайн "Жамухын очил" өгүүллэгийн "Найман зууны тэртээх Жамухын шарил дээгүүр өнөөдөр талын болжмор жиргэж, эх нутгийн ноён салхинаа гудайсан хялганын толгой гашуудалтайяа бөхөлзене" гэсэн хэсэглэлээс зохиолчийн сонгосон өвөрмөц үг, уран дүрслэлийг ялган бичиж, утгыг тайлбарлаарай. /2 оноо/

Уран

дүрслэл:

Утгын
тайлбар:

В. Уран зохиолын хичээлээр үзсэн зохиолоос нэгийг сонгож мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн 60-70 үгэнд багтаан бичзэрэй. /5 оноо/

6. Дараах эхийг үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

وَلِيَقْرَأُكُمْ مَا تَعْمَلُونَ إِنَّمَا يَنْهَا عَنِ الْمُحَاجَةِ
أَنَّهُمْ لَا يَعْلَمُونَ وَإِذَا قُرِئَتِ الْآيَاتِ
فَيَقُولُ الَّذِينَ لَا يَعْلَمُونَ أَنَّهُمْ لَا يَهْدَى
إِنَّمَا يَنْهَا عَنِ الْمُحَاجَةِ أَنَّهُمْ لَا يَعْلَمُونَ

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

10 оноо

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР *бажыл* д.БАЙГАЛМАА

Материал засссан: Бааш

БАТЛАВ
ЗАХИРАЛ М.АЮУШХОРЛОО

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
10 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.10
Нийт оноо: 40

Хугацаа 80 минут
Анги:

В хувилбар Сурагчийн нэр:

Хэрлэн сүм

Эхийг анхааралтай үншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

Кино миний амьдрал

1970, 1980-аад оны дэлгэцийг эзэнэн гялалзсан Монгол улсын Гавьяат жүжигчин Нацагдоржийн Батцэцгийн тухай өгүүлэх болно. 1970-аад оноос хойш өдгөө хүртэл дэлгэцийн урлагт зүтгэсэн амь амьдралаа зориулсан 50-иад жилийн түүх. Торгон алаг нүдтэй үзэсгэлэнт монгол бүсгүй Нарангарауу эх нутгийнхаа амин булагт бөлжээ өргөж босоход зүрхэндээ хайр, нүдэндээ нүүлийн түүхийн эхийн одоо ч түүнтэй хамтдаа байгаа гэдэгт итгэнэм.

"Би дөнгөж оюутан болоод байхдаа киноны дүр хайж байгаа уран бүтээлчидтэй санамсаргүй тааралдсан. Энэ бол Төрийн соёрхолт, ардын уран зохиолч С.Эрдэнийн "Нарангартвуу" өгүүллэгээр сэдэвлэсэн Төрийн соёрхолт, ардын уран зохиолч С.Дашдооровын зохиол "Эх бүрдийн домог" кино юм. Найруулагч нь Ардын жүжигчин Г.Жигжид, Урлагийн гавьяат зүтгэлтэн Ж.Бунтар нар байлаа" хэмээн кино урлагийн амьдралд хөл тавыж байлаа хэмээн дурсан сууна. Монголын төдийгүй гадаад улс орны үзэгчдийг байлдан дагуулж, Карл Варын олон улсын кино наадмын Гран при шагналыг монголдоо авчирсан "Эх бүрдийн домог" киноны гол дүрийг бүтээж домог амилуулахдаа Н.Батцэцэгт 18 настай байлаа. Намайг их сургуулиа төгсөөд Кино үйлдвэрт ороход жүжиг ангид олон жүжигчид байсан, дуу оруулахад сургасан, өвөлдөө кинонд дуу оруулж, зундаа кинонд тоглодог байлаа. Зах зээл хүртэл Кино үйлдвэртээ ажиллаж байгаад 2000 оноос хувийн кино студийг байгуулж уран бүтээл хийж эхэлсэн.

Монголын дэлгэцийн урлагийн өндөр үүдээр эрхэмсгэр орж ирсэн Батцэцэг "Эх бурдийн домог", "Дэгдээхэй нас", "Хүний амь", "Суварган цэнхэр уулс", "Тойрох хуудас" зэрэг олон кинонд тогlossen нь мэргэжлийн жүжигчин хүнд одоод байдаггүй тун чиг ховорхон хувь заяа. Урлаг судлаач Дэ.Мягмарсүрэн "Нацагдоржийн Батцэцэг нь 1970-аад оны дунд үеэс монголын кино урлагт гарсан онцгой үзэгдэл. Хамгийн гол нь дотоод сэтгэлээр дүрээ бүтээж чаддаг ухаалаг жүжигчин" хэмээжээ. "Суварган цэнхэр уулс" кино дэлгэцэнд гарснаас хойш охид сэтгүүлч болохыг мөрөөдөж, бүсгүйчүүд цэнхэр пансан алчуураар гоёж, аваа зэжүүд охин үрдээ Солонго хэмээн нэр хайлрakh байсан нь энэ дүр үзэгчдийн сэтгэлийн утсыг ямархан их хөглөсний баталгаа төдийгүй Батцэцэг шиг үзэсгэлэнтэй, ухаалаг бүсгүй болохын мөрөөдөл, далдхан бэлгэдэл гэлтэй. "Гэрлэж амжаагүй явна", "Газарчин" зэрэг кино нь түүний залуу насны аз гийж, од гэрэлтэж явсны гэрч билээ. Газарчин кинонд тогlossen нь Германы уран бүтээлчдэд монгол бүсгүйн авьяас билиг, эрэмгийн зан, үзэсгэлэнтэй, дотоод мөн чанарыг гойд таниулж, баходан гайхашруулсан нь лавтай.

Монгол кино үйлдвэрийн дарга Ж.Солонго "Удирдан ажиллаж байсны хувьд монгол киноны нэгэн үеийн бүхий л кинонд тоглож байсан уран бүтээлч. Ачаалал даах чадвартай, 2000 онд 3 кинонд зэрэг гол дүр бүтээн ажиллаж байлаа. Нийтэч, бүхий л ажил төрөлд оролцдог, түүгээрээ бусдыг татдаг, хүн чанартай", Монгол кино үйлдвэрийн Жүжиг ангийн дарга Б.Бямбажав "100 гаруй кинонд дуу оруулсан, налзээд кинонд гол дүрд тоглосон, авьяаслаг, хүн чанратай", Монгол кино үйлдвэрийн жүжигчид "Одоо хэр нь биднийг цуглуулж, эвтэй найртай байлгах гэж хичээж байдаг хүн чанарт нь баярлаж, хундэтгэж, биширч явдаг даа", "Манай Батцэцэг зөвхөн жүжигчний ажлаа хийхээс гадна өөрийн хийе гэснээс хийдэг, хамт олныг бурдуулдаг, хүнлэг, энэрэнгүй, сайхан сэтгэлтэй бүсгүй гэж ам бардам хэлнэ", "Манай Батцэцэг их дайчин, хэлний боловсрол сайтай, маш их юм уншдаг, бүх ахмадаа жил бүр амраптад амраадаг, хувийн зохион байгуулалт сайтай", "Ямагт санаа тавьж байдаг, манай монголын кино урлагийн төлөө ямар ч ажлыг хийдэг, сэтгэлтэй, ажилсаг бүсгүй" хэмээн дурсан ярьсаар... Гэтэл Ардын уран зохиолч Б.Догмын "Миний олон зохиолыг шивж өгсөн, киноны ахуй нөхцөл, менге санхүү, жүжигчний тал, бүхий л талаас бүгдийг нь бэлтгэдэг, зохион байгуулдаг, удирддаг. Жинхэнэ киноны хүн", Ардын жүжигчин Цэрэндагва "Кино мөхлөө, сенелөө гэж байсан цаг үед Батцэцэг хамтарч ажиллах саналыг тавьж байсан. Эдийн засаг, нийгэм ороо бусгаа хэцүү цаг үед кино группыг зохион байгуулж явсан үзэсгэлэн төгс монгол эмэгтэй, мөн үйгагүй бүтээлч, хөдөлмөрч чанар нь бусдаас ялгарч байдаг юмаа" хэмээн баходан өгүүлнэ.

Өөр өөр цаг үеийн сүү үнэртэж, хайр асгарсан эх хүн, нинжин сэтгэлт монгол бүсгүйн дүр төрхийг дэлгэнээ сайхан амилуулж, өөрийн гэсэн тод мөртэйгөөр үзэгчдийг байлдан дагуулсаар байгаа Батцэцэг сайхан сэтгэл, гоо үзэсгэлэнгээрээ гэрэлтэж, улам улам үндрах авьяас онгodoороо жигуурлаж явна. **Батцэцэг хөрөө нэвтрүүлэг ([youtube.com](https://www.youtube.com))**

1. Өгүүлбэрүүдийн төгс бус өгүүлэхүүн пишүүний илрэх байдлыг ажиглан, дүгнэлт гарган зөв харгалзуулаарай. /4 оноо/

A. Өөр өөр цаг үеийн сүү үнэртэж, хайр асгарсан эх хүн.	1. УНӨ
Б. Карл Варын олон улсын кино наадмын Гран при шагналыг монголдоо авчирсан "Эх бүрдийн домог" киноны гол дүрийг бүтээж домог амилуулахдаа Н.Батцэцэг 18 настай байлаа.	2. Холимог нийлмэл өгүүлбэр
В. "Гэрлэж амжаагүй явна", "Газарчин" зэрэг кино нь түүний залуу насны аз гийж явсны гэрч билээ.	3. Харьяалахын тодотгол пишүүн өгүүлбэртэй УНӨ
Г. Эдийн засаг, нийгэм ороо бусгаа хэцүү цаг үед кино группыг зохион байгуулж явлаа.	4. Цагийн утгатай байц пишүүн өгүүлбэртэй УНӨ

Түлхүүр:

2. Эхэд байгаа "Ямагт санаа тавьж байдаг, манай монголын кино урлагийн телөө ямар ч ажлыг хийдэг, сэтгэлтэй, ажилсаг бусгүй" хэмээн дурсан ярьсаар... Гэтэл Ардын уран зохиолч Б.Догмид "Миний олон зохиолыг шивж өгсөн, киноны ахуй нөхцөл, мөнгө санхүү, жүжигчний тал, бүхий л талаас бүгдийг нь бэлтгэдэг, зохион байгуулдаг, удирддаг. Жинхэнэ киноны хүн" гэсэн өгүүлбэрийн тодруулсан үгийн үргийг тодорхойлж, утга ойролцоо үзээр солин найруулаарай. /4 оноо/

Үүрэг:

Солин найруулсан нь :

3. Өгүүлбарт онцолсон бүтээврийг солин найруулж бичээд, холбох үгийн утгыг тайлбарлаарай.
\\ 4 оноо \\

"Батцэцэг сайхан сэтгэл, гоо үзэсгэлэнгээрээ гэрэлтэж, улам улам ундрах авьяас онгodoороо жигүүрлэж явна."

Солин найруулсан нь:

Утгын

тайлбар:

4. Зөв бичих дүрмийн даалгавар \\4 оноо\\

А. Дараах үгсээс алдаатай бичсэн 1 үгийг олоод, зөв болгон бичээрэй.

Үгс: Шамарга, бодсоноор, суврага, санаачилга, пижгэнэх, томьёо

Алдаатай үг: Зөв болгосон нь:

Б. хавсар + лт үгийн язгуур үндсэнд бүтээврийг залгаж бичээд, дүрмийг тайлбарлаарай.

Үг:

Дүрэм:

5. Уран зохиолын даалгавар: /9 оноо/

А. Д.Нацагдоржийн "Хөдөө талын үзэсгэлэн" өгүүллэгийн онцолсон хэсгийн хам сэдвийг тодорхойлоорай. /2 оноо/

Сүлжилдэн давхилдах хөдөөгийн хүмүүсийн цэнгэл нь миний сэтгэлийг даруй баходуулж, Сан бэйсийн морины сайхан нь миний дурыг хөвөлзүүлэн хөдөлгөнө. Монгол газар минь уужим юмаа. Маш сайхан морьтой юмаа, морио унаад давхихад манай цог заль сэргэнэ. ... Энгэр нударгыг хар торгоор эмжиж, нарийхан хошмог тавьсан хүрэн ягаан чисчүү дээлийг өмссөн, зуун ханцуй дотроос нарийхан хурууг цухуйлган, жолоо цулбуурыг хугас барин атгаад баруун ханцуйгаа сул тавин, түүний дотор гарваа нуун ташаагаа тулж, буулгасан том нударгыг далбайлган бүрхүүлсэн нь шинэ цагийн хээнцэр байдлыг гайхуулжээ.

Хам сэдэв:

Б. Д.Намсрайн "Жамухын өчил" өгүүллэгийн "Найман зууны тэртээх Жамухын шарил дээгүүр эх нутгийн ноён салхи гунигтайхан хэсүүчилж нөхрийн тухай үгсийг хялганын бутанд шивнэн эрин зуунд илгээнэ" гэсэн хэсэглэлээс зохиолчийн сонгосон өвөрмөц үг, уран дүрслэлийг ялган бичиж, утгыг тайлбарлаарай. /2оноо/

Уран

дүрслэл:

Утгын

тайлбар:

В. Уран зохиолын хичээлээр үзсэн зохиолоос нэгийг сонгож мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн 60-70 үгэнд багтаан бичээрэй. /5 оноо/

6. Дараах эхийг үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

لَمْ يَعْلُمْ عَوْنَاحُ مُؤْمِنًا بِهِ حَتَّىَ كَانَ مُؤْمِنًا مَعْنَىً وَلَا مُؤْمِنًا مَعْنَىً،
لَمْ يَعْلُمْ دُخُولَةَ الْجَنَّةِ حَتَّىَ كَانَ دُخُولَةَ الْجَنَّةِ، لَمْ يَعْلُمْ نَفْرَاتَ
الْمَسْكُونَيْنِ حَتَّىَ كَانَ نَفْرَاتَ الْمَسْكُونَيْنِ، لَمْ يَعْلُمْ مُؤْمِنًا مَعْنَىً حَتَّىَ كَانَ

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

/10 оноо/

Өөрийн ойр дотны болон олны танил хүмүүсээс нэгийг сонгож, мэдрэмж сэтгэгдэл, үнэлэмжээ илэрхийлэн, баримтад тулгуурлан 150-180 үгэнд багтаан хөрөг найруулал бичээрэй.

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР *баян* Д.БАЙГАЛМАА

